

ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН УХАМСРЫН ТӨЛӨВШЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Г.Цэнд-Аюуш ахлах багш

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Түлхүүр үг: оюутан залуучууд, улс төрийн ухамсар, оюутны насны хязгаар, сургалт, хүмүүжлийн систем

Товч агуулга: Оюутан залуучуудад улс төрийн ухамсар төлөвшүүлэх арга зам, үндсэн хэлбэрүүд ба залуучуудын асуудалд хандсан судлаачдын гол хандлагууд. Улс төрийн ухамсрын төлөвшилтөд их дээд сургуулиудад заагдаж буй нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаануудын гүйцэтгэх үүрэг, мэдээллийн нөлөө, ач холбогдол.

Монгол түмэн эрт, эдүүгээ үед ч эрх чөлөө, тусгаар тогтнол, бүтээн байгуулалт, өөрчлөлт, шинэчлэлийн төлөө тэмцэл хөдөлгөөнд түүхэн үүрэг гүйцэтгэж ирсэн ба энд залуучуудын тэр тусмаа тооны хувьд төдийгүй нийгмийн идэвхтэй бүлэг болсон оюутан залуучууд зохих ёсны байр сууриа эзлэх нь тодорхой билээ. Өдгөө манай орны хүн амын 70 шахам хувийг 35 хүртлэх насны залуучууд эзлэж байгаагийн дотор төрийн болон хувийн хэвшлийн их, дээд 170 гаруй сургуулиудад 140 гаруй мянган оюутан суралцаж байна (Зууны мэдээ. 2007.10.11. №244)

Залгамж үеэ тодорхой зорилго чиглэлтэй бэлтгэж хүмүүжүүлж, төлөвшүүлдэггүй нэг ч ард түмэн, улс үндэстэн байдаггүй билээ. Оюутан гэдэг бол манай ард түмэн хүмүүжил, боловсролын тодорхой системээр бэлтгэн төлөвшүүлж буй залуу үе мөн. Тэгвэл оюутан гэж хэн бэ? Тэдэнд эзэмших ёстой нийгмийн ухамсар, түүний дотор улс төрийн ухамсрын мөн чанар, бүрдэл хэсгүүд юу болох, оюутан залууст улс төрийн ухамсар төлөвшүүлэхэд нөлөөлдөг хөшүүргүүд юу болохыг хөндөж илэрхийлэх нь багш оюутны сургах, суралцах хөдөлмөрийн аль алинд нь холбогдох билээ. Оюутан залуучууд сэтгэл зүй-насны болон нийгэмд эзлэх байр, гүйцэтгэх үүргээрээ өвөрмөц онцлогтой нийгмийн тодорхой бүлэг юм. Оюутан залуучуудад нийгмийн бүлэгт байх бүх шинжүүд байхаас гадна бас нийгмийн бусад бүлгүүдтэй харьцуулбал биеэ даасан шинжтэй байх, амьдрал, хөдөлмөр аж байдлын өвөрмөц нөхцөл, нийгмийн үйл байдал, сэтгэл зүй үнэлгээний систем бүхий өвөрмөц бүлэг мөн. Оюутан залуучуудад нийт залуу үеийнхэнд хамаарах нийтлэг шинжүүдээс гадна суралцах хөдөлмөртэй нь холбогдсон өвөрмөц шинжүүд: энэ нь тэдний эрхэлж буй хөдөлмөрийн онцлог, нийгмийн зохион байгуулалтад гүйцэтгэх хөдөлмөрийн үүрэг, иргэн, сэхээтэн, мэргэжилтэн болохоор бэлтгэгдэж байгаа хугацаа зэрэгтэй нь холбоотой юм. Эрдэм шинжилгээний ном зохиолд

залуучууд, залуу насны хязгаарыг тодорхойлсон нэлээдгүй олон тооны хандлагууд тааралддаг бөгөөд тэдгээрээс хамгийн нийтлэг гэж хэлж болмоор хандлагуудыг авч үзье.

1. нийгэм- сэтгэл зүйн хандлагаар залуучууд бол өөрийн биологи, сэтгэл зүйн харилцаагаараа ялгарах тодорхой насны хязгаар бүхий бүлэг.
2. Мөргөлдөөний хандлагаар залуу үе–“амьдралын төвөгтэй, сэтгэлийн дарамт, бухимдлаар дүүрэн онцгой чухал үе”, “хувь хүн ба нийгэм хоёрын хоорондын зөрчил зааглагдах үе”, “хүний хөгжил дэх асуудалтай үе шат”.
3. Субкультурный хандлагаар залуучууд бол өөрийн өвөрмөц аж төрөх ёсны, үйл байдлын хэв загвартай, соёлын хэм хэмжээ, үнэт зүйлс бүхий бүлэг.
4. Стратификацийн хандлагаар залуучууд- насны заагаар хязгаарлагдсан, нийгмийн байр суурь, статус үүргээрээ өвөрмөц нийгэм – хүн ам зүйн бүлэг.
5. Нийгэмшлийн хандлагаар залуу үе бол анхдагч нийгэмшилтийн социаль өсөлтийн үе. Идэр насанд бие даах чанар, мэдрэмж эрчим далайцтай хөгждөг.
6. Аксиологийн (үнэт зүйлийн) хандлагаар залуу үе- хүний амьдралын мөчлөг дэх нийгмийн ач холбогдол бүхий чухал үе шат.
7. Процессуаль хандлага- залуу хүн бол төлөвшиж, төвлөрч гүйцээгүй, бүрэлдэн төлөвших шатандаа байгаа хүн.

Дээр өгүүлсэн олон янзын хандлагуудын эерэг (позитив) зүйлийг нэгтгэн авч үзэх нь залуучуудын талаар нэгдмэл ойлголттой болоход чухал ач холбогдолтой учир энд бид тэдгээр хандлагуудад үнэлэлт өгөх, тэр тусмаа шүүмжлэх оролдлого хийгээгүй болно. Дээрхи хандлагуудтай танилцаж түшиглэсэний үндсэн дээр залуучуудын талаархи ойлголтод юуны түрүүн насны хязгаар, нийгэм- сэтгэл зүйн онцлог, социаль статус (нийгэмд байр сууриа эзлэх), үйл байдал, үүргийн өвөрмөц тал, нийгэм-хүн ам зүйн онцгой бүлэг болохын хувьд нь нийгэмших үйл явцын онцлогийг тусгаж үзэх шаардлагатайг дүгнэн тэмдэглэж байна.

Залуучууд бол ерөнхий боловсрол, мэргэшлийн болон соёлын функцийг эзэмших, (боловсорсон насандаа эзэмшсэн) насанд хүрсэн хүмүүсийн нийгмийн үүргийг орлох ба гүйцэтгэхээр нийгмээс бэлтгэж байгаа (бэлтгэгдсэн) нийгэмшлийн шатыг дамжиж яваа хүмүүсийн үе мөн. Эндээс харахад залуучуудын тодорхойлолтонд зайлшгүй тусгагдах зүйл гэвэл: **нэгд**, залуучууд нь насны хязгаар бүхий өвөрмөц том дэд бүлэг, нийгмийн салшгүй нэг хэсэг. **хоёрт**, асар их оюуны болон бүтээлч эрч хүчийг тээгч, **гуравт**, түүхэн –тодорхой үзэгдэл бөгөөд нийгмийн өөрчлөлтийн социаль тэжээл, **дөрөвт**, нийгэмшлийн объект, субъект, өөрийн сонирхлыг өөрөө ухамсарлах субъект, **тавд**, ирээдүйн бүтээн байгуулалтын нөөц, хүчний ундрага болох нь тодорхой харагдаж байна.

Оюутан залуучуудын улс төрийн ухамсрыг төлөвшүүлэхэд улс төрийн нийгэмшлийн гол агент болсон дээд сургууль, залуучуудын нийгэм-улс төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг онцгой ач холбогдолтой нь тодорхой. Дээд

сургуулийн орчинд л залуучуудын улс төрийн хүмүүжил бүрэлдэн тогтоно. Сургалтын явцад тэд төрийн байгууламж, нийгмийн улс төрийн систем, улс төрийн үйл явцын тухай төсөөлөлтэй болж иргэн хүний хувьд энэ үйл явцад оролцох хүсэл тэмүүлэл нь өдөөгдөнө. Судалгааны дүнгээс харахад нийгэм-хүмүүнлэгийн салбарын оюутнууд сургалтаар олж авсан мэдлэг, мэдээлэлийн цар хүрээ, мөн сонгож авсан мэргэжлийн онцлогоосоо хамааран нийгэм-улс төрийн амьдралын үйл явцад оролцох байдал нь илүү идэвхитэй байдаг байна. Харин бусад мэргэжлийнхний хувьд улс төртэй төдийлөн ойр биш байдаг тул энэ тал дээр арай өөр дүр зураг социологийн судалгаанаас харагдаж байгаа юм. Нийгэм-хүмүүнлэгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад багшлах болон нийгэм-улс төрийн ажлын танилцах дадлага хийлгэх болсон нь ач тусаа өгдөг сургалт хүмүүжлийн үр дүнтэй хэлбэрийн нэг юм.

Дээд боловсролтой мэргэжилтэй боловсон хүчний үүргийг сайн эзэмшихийн тулд оюутан залуучууд шинийг эрэлхийсэн сурч мэдэх оргилуун эрмэлзлэлтэй өөрийгөө бүрэн дайчлах чадвартай байх учиртай. Дээд сургуулийн өдрийн ангид 18-35 насны залуучуудыг элсүүлдэгийн цаад учир үүнтэй холбоотой хэрэг. 35-аас дээш насны хүмүүсийг элсүүлвээс дээр өгүүлсэн чанар нь буурчихсан байх учир дээд боловсролыг сайтар эзэмшиж чадахгүйд хүрнэ гэсэн үг. Оюутан залуусын насны дээд хязгаар нь “залуучууд” гэсэн ойлголтонд багтах хүмүүсийн насны дээд хязгаартай дүйж байгаа юм²¹. гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Авторитар тогтолцооны үед оюутнууд нь нэг хэв загварт баригдмал, ихээхэн улс төржиж үзэл сурталжсан хичээл үздэг, намын их, бүгд хурлын материал, эх зохиол судалдаг, семинарын хичээл зөндөө хийдэг, орос хэлийг төрөлх хэлнээсээ илүүтэй шахам үздэг байсан бол өнөөгийн оюутнууд тэдгээр дарамтаас чөлөөлөгдөж, бие даасан бүтээлч байдалд шилжиж эхэлж байна.

Тиймээс энэхүү ардчилсан шилжилтийн үеийн оюутан залуучуудын онцлог бол нийгмийн хөгжлийн эрч далайцтай үе шатанд тэд өсөн бойжиж, хүмүүжиж байгаад оршино. Энэ бүхний үрээр ухамсар, соёлын хүртэх хүрээ нь өргөжин тэлж ухамсарт үйл ажиллагааны суурь дэвсгэр өргөсөж байна. Түүний хажуугаар нийтлэг харилцааны хэрэгсэл (радио, кабелийн телевиз, компьютер, гар утас, интернет, ном, сонин г.м) хүнд хүрч очих мэдээллийн хир хэмжээг асар ихээр нэмэгдүүлэн, залуучуудын мэдлэг, сонсож дуулсан, үзсэн харсан юмсын хэмжээ дамжааг хэзээ хэзээнээс илүү ихээр ахиулсан, тэдэнд аливаад бүтээлчээр хандах чадварыг бий болгож, аливаад өөрт төлөвшиж бий болсон ухамсар, ойлгоцын төвшингээс хандах бололцоог бүрдүүлж боловрол, соёлын төвшинг нь дээшлүүлсээр байна. Эндээс үзвэл өнөө үеийн оюутан залуучууд нь цаг үеийн бололцоо, нөхцөл байдлын давуутайн ачаар ахмад үеийхнээсээ харьцангуй өндөр боловсролтой “залуучуудын, арай илүү боловсрогдсон, бэлтгэгдсэн тэр чанараараа нийгэмд тэргүүлэх байр суурьтай хэсэг”²² болжээ. Дээд боловсролын системд оюутан залуучууд нь нийгэмших хоёр үндсэн шатыг

²¹ Н.В.Боряз. "Человек и общество" М., 1969.с.23-24

²² В.Г.Лисовский, А.В.Димитров. Личность студентов. МГУ., 1974. с.31.

дамждаг. Нийгэмшлийнхээ анхны шатанд залуучууд дээд сургуульд элсэн орж, нийгмийн гарлаар харилцан адилгүй оюутнуудын нийгэм бүлгийн нэгдэлд хамрагддаг. Хоёр дахь шатны нийгэмшил нь нийгэмд онцгой (сэхээтний, мэргэжлийн, зохион байгуулалт-удирдлагын, соёл-хүмүүжлийн гэх) үүргээ биелүүлэхэд нь бэлтгэхэд оршино. Ингэхлээр оюутан залуучуудыг сургаж хүмүүжүүлэх, бас тэдэнд улс төрийн ухамсар, соёлыг төлөвшүүлж хэвшүүлэх ажил харилцан хамааралтай болохыг энд тэмдэглэх нь зүйтэй.

Ер нь боловсрол хичнээн өндөр байх тусам улс төрд илүү анхаардаг, улс төрийн ээдрээтэй нөхцөлд бие даасан зөв алхам хийх, улс төрийн үйл явдлыг үндэслэлтэй тайлбарлах, үнэлэлт өгөх, нөлөөлөх чадвар давуу байдаг нь нэгэнт тодорхой байдгийг²³ судлаачид тэмдэглэсэн байдаг. Тиймээс ч европын боловсролын систем нийгмийн бүлэг, давхрагын ялгаварын талаархи хуучирч үеэ өнгөрөөсөн ойлголтыг халахыг чухалчилдаг нь цаашдын улс төрийн нийгэмшлийн үр дагаварыг тооцож үзсэн хэрэг.

Нийгмийн гишүүдэд ардчилал, ил тод байдал, олон ургалж байдлын үзэл санааны утга учрыг ухамсарлуулах ажил хүмүүнлэг иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг зорьж буй төрийн хувьд, нийгэм-улс төрийн багш сурган хүмүүжүүлэгч бидний хувьд сургалтын хойшлуулашгүй зорилт болж байна.²⁴ гэж манай судлаачид онцолсон байдаг. Гэхдээ оюутан хүн иргэн хүн болж төлөвших, улс төрийн төдийгүй ерөнхий соёл, ертөнцийг үзэх үзэл бодол, үйл байдал бүрэлдэн төлөвшихөд тухайн нийгмийн улс төрийн систем, хүрээлэн буй макро, микро орчин ихэд нөлөөтэй болох нь олонхи эрдэмтдийн зохиол бүтээлд туссан судалгааны материалаас тодорхой харагддаг. Ер нь хувь хүн иргэн болж төлөвших, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн тухай формацийн онол, номлол хүнийг нийгмийн харилцааны объект төдийгүй субъект байх учиртай хэмээн авч үздэг бөгөөд хүн нийгмийн харилцааны объект байна гэдэг нь тухайн тэр нийгмийнхээ онцлогийг өөртөө агуулна, эрэлт хэрэгцээ шаардлаганд захирагдана. Субъект байна гэдэг нь тэрхүү эрэлт хэрэгцээ шаардлагыг ухамсарлан ойлгож өөртөө шингээхийн хирээр эргээд нийгэмдээ нөлөөлж тодорхой тодорхой чиглэлээр өөр өөрийн гэсэн үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг. Формацийн онолын энэхүү үзэл санаа одоо ч шинжлэх ухааны үнэ цэнээ алдаагүй, судалгаа шинжилгээний ажлын арга зүйн чиг баримжааны нэг болсоор байна. Энэ талаар доктор Н.Хавх бичихдээ "аль ч нийгэмд тэр нь буруу аргаар байгуулагдаад, сүүл рүүгээ оршин байхаа больсон "социалист" нийгэмд ч, чөлөөт өрсөлдөөнөөр жигүүрлэсэн, хувийн өмчийн тогтолцоот одоогийн нийгэмд ч нийгэм, хүн хоёр харьцсаар л : хүн түүний дотроос залуучууд нийгмийн харилцааны объект, субъект байсаар л : зөрчлийг бий болгогч, тэдгээр талууд нь хүн хийгээд нийгэм, объект хийгээд субъект хэмээх өөр хоорондоо зөрчилт, диалектик зүй тогтлоор холбогдсоор байх болно"²⁵ гэжээ.

²³ Ё.Довчин. Харьцуулсан улс төр., УБ., 2006, 277-р тал

²⁴ Проблемы формирования личности в МНР. Автореф Дисс, 1991, с.21. Л.Цэенбазар

²⁵ Н.Хавх. Оюутан залуучуудын нийгмийн харилцааны гүн ухааны агуулга.УБ., 2002. 47-р тал

Аливаа улс үндэстэн бүр өөрийн гэсэн соёл иргэншилтэй, тэр нь өгсөн цэцэглэж, уруудан доройтож, дахин цэцэглэн мандах зэргээр улиран дэвшин хөгжинө. Соёл иргэншдүүд гол төлөв хоёр хоёроор зөрчлийг бий болгодог. Тухайлбал, нүүдэл хийгээд суурьшлын, дорно хийгээд өрний, их гүрний хийгээд бага буурай орны гэх мэт бий: тэд харилцан бие биеэ нөхцөлдүүлэхийн хирээр үгүйсгэн байж, түүхэнд байгаа харилцан солилцон үүргээ гүйцэтгэсээр дэлхийн соёл иргэншлийн хөгжил урагшаа ахина гэсэн санааг арга зүй болговол ирээдүйд улс үндэстний эв нэгдэл нэмэгдэнэ, улсаа үндэстнээ гэсэн үзэл бодол лавшран бий болно: ийнхүү улсаа бодох хамтач үзэл шингэж тэд улс нийгмийнхээ төлөө эрч хүчтэй тэмцэнэ, тэмцэхийн хирээр улам эв нэгдэл, нягтралыг олж аваад "дуулвал дуу нэг, дугтравал хүч нэг" болно, хэрэв улс үндэстний уруудах шатнаас хүн ардын олонхид нь "хувиа бодож, довоо шарлуулах" үзэл бодол давамгайлж өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдэнэ, түүний хирээр эв нэгдэл нь эвдэрч задлал бутралд орно. Ингэхлээр хөгжил өгсөж байхад хүмүүс "хувиа хичээх "бодлоосоо" "нийтийн сайн сайхны" төлөө байх бодол нь хүмүүст түлхүү төлөвшинө.

Зөвлөлт, оросын эрдэмтэн И.С Кон бичихдээ" ухамсарлагдан өөрийшсэн үзлийг хамт олны үзэл бодлыг өөрийн болгох замаар өөрийгөө хамт олны салшгүй нэгэн хэсэг болгох чадварыг хэлнэ"²⁶ гэсэн байдаг. Хүний ухамсар бол сэтгэл санаа, оюун ухаан хоёрын нэгдэл мөн бөгөөд ухамсрыг сэтгэл санааны, танин мэдэхүйн, үйл байдлын гэсэн гурван бүрдлийн нэгдэл хэмээн үзэж болно.

Өнөөдөр улс төрийн ухамсрын судлах зүйлийн төрөлд нийгэм, бие хүний амьдрал үйл ажиллагааны бараг бүхий л талууд хамрагдах болсныг судлаачид тэмдэглэн бичих боллоо²⁷. Иймд залуучуудын талаарх судалгаа шинжилгээний ажил нийгэм хувьсаж өөрчлөгдөх бүх түүхэн үе шат, онцлогыг төдийгүй тэдгээр түүхэн үеүд дэх нийгмийн бүлэг, давхрааны бүтцийн өөрчлөлт, хувьслыг тусган холбох хэрэгцээ шаардлагатай нөхцөлдөх нь тодорхой юм. Энэ талаар Зөвлөлт, оросын социологич С.Н.Иконикова "залуучуудыг" нийгмийнх нь хэв маягтай, нийгэм дэх социаль бүтцийн ялгаралтай, улс төрийн байгууллын шинжтэй, үндэстэн ястны онцлогтой, нийгмийн тогтолцоонд залуучуудыг өөрсдий нь эзлэх байр суурьтай, нийгмийн амьдралд тэдний оролцож буй хир хэмжээтэй холбон судлах нь зөв хэмээжээ ²⁸.

Тиймээс оюутан залуучуудад улс төрийн ухамсар төлөвшүүлэх хоёр үндсэн арга замыг судлаачид дэвшүүлж байгаа бөгөөд тэдгээр нь бие биесээ харилцан нөхцөлдүүлдэг аж. Эхнийх нь "хичээлийн анги танхимаар" дамжуулж оюутан залуучуудад шинжлэх ухааны үндэслэлтэй улс төрийн мэдлэг, боловсролыг онолын төвшинд хүртээж олгох үндсэн дээр тэдэнд нийгэм-улс төрийн аливаа үзэгдэл, үйл явцад улс төрийн зохих төвшингийн мэдрэмж, соёлтой өөрийн ухамсартайгаар хандах чиг хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Нөгөө нь "хичээлийн анги танхимаас гадуурхи" буюу оюутан

²⁶ И.С.Кон. Психология юношеского возраста.М.,1979.с.108 Социология личности М.,1967.

²⁷ Современное политическое сознание США.М.,1980.с18-19.

²⁸ С.Н.Иконикова.Молодежь .Изд-ва МГУ.М.,1974.с.9

залуучуудын улс төрийн ухамсарын эмперик төвшний төлөвшилт бөгөөд сургалтын явцад олж авсан системтэй онолын мэдлэг, чадварыг тэдний эмперик ажиглалтууд, практик үйл ажиллагаанд нь шингээж батжуулахад чиглэгдэнэ. Дээрхи хоёр үндсэн арга зам диалектик холбоотой бөгөөд эхнийх нь хүмүүжүүлж сургах, удаах нь сургаж хүмүүжүүлэх чиг үүрэгтэй ба мэдлэгээс итгэл үнэмшилд, түүнээс практикт гэсэн зарчмыг удирдлага болгохын дээр гол шалгуур нь улс төрийн мэдлэг, мэдрэмж, баттай итгэл үнэмшил юм. Оюутан залуус нийгмийн томоохон бүлэг хэсэг болохынхоо хувьд нийгмийн улс төрийн амьдралд оролцох тэдний оролцоо нь улам бүр өсч байна. Олон ургальч үзэл хөгжиж ардчилал ил тод байдлын давалгаа өрнөж байгаа өнөө үед оюутан залуучуудын улс төрийн ухамсарын төвшин хандлагыг тэдний аргын ухамсрын суурь дээр чиглэсэн зорилготой төлөвшүүлэхэд их, дээд сургуулиудад заагдаж байгаа нийгмийн ухааны сургалтын систем онцгой ач холбогдолтой болж байна. 1991 онд Шинжлэх ухаан боловсролын яамны (хуучнаар) сайдын тушаал гарч улс төр судлалын хичээлийг их, дээд сургуулиудад албан ёсны сургалт болгож заах шийдвэр гарсан билээ. 1993 оноос Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн дэргэд улс төр судлалын салбар ангийг нээж, улс төрийн шинжлэх ухааны анхны мэргэжилтнүүдийг бэлтгэх ажил эхэлсэн.

Нийгмийн ухааны сургалтын явцад тэдний нийгэм улс төрийн ухамсар үйл байдлын идэвхижилт, өсөлтөд үр нөлөөгөө өгөхүйц бодит байдлын олон талт үзэгдэл юмсыг шинжлэх ухаанаар танин мэдэх, төр улс төрийн намуудын дэвшүүлсэн эдийн засгийн бодит арга хэмжээг үнэлэх тодорхой үнэлэмжтэй болгох зорилго хэрэгжиж байх ёстой. Их, дээд сургуулиуд дахь нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны хичээл Монгол улсын түүхийн хичээлээр эхэлдэг.

1. Монголын түүх бол оюутан залуусын үндэсний болон иргэний ухамсарт чанарыг төлөвшүүлэх, тэдэнд түүхэн үзэгдлийн учир холбогдлын шалтгааныг илрүүлэн дүгнэх үндсэн дээр нийгмийн хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх онолын бэлтгэл суурийг тавьдаг юм.

2. Философийн шинжлэх ухааны үүрэг бол ертөнцийг танин мэдэх диалектик аргыг эзэмшүүлэх, энэ үндсэн дээр нийгэм-улс төрийн үзэл санаа байр сууриа тодорхойлох цэгцтэй системийг төлөвшүүлэх явдал онцгой ач холбогдолтой.

3. Улс орон зах зээл, чөлөөт өрсөлдөөний хөгжлийн хандлагад татагдан орж байгаа нь тэднээс нийгмийн үзэгдлүүдтийн эдийн засгийн үндсийг ойлгох улмаар аж ахуй удирдлагын үйл явцын үр ашигтай хэлбэр, механизмыг боловсронгуй болгож оролцох явдлыг зүй ёсоор шаардана. Иймд эдийн засгийн онолын хичээлийн үүрэг өсдөг байх болно.

4. Улс төрийн шинжлэх ухаан оюутан залууст төр ба нийгэм, иргэдийн хоорондын зохист харилцааны талаархи ойлголт бүрэлдүүлэх улмаар улс төрийн системийн хөгжлийн үйл явц, энэ үйл явцад иргэн хүн, эрх үүрэг, эрх чөлөө, чөлөөт байдлаа олж ухамсарлах бололцоог олгох зорилт тавигддаг онцлогтой юм.

Ийнхүү их, дээд сургуульд заагдаж буй нийгмийн шинжлэх ухаанууд оюутан залуучуудын нийгэм-улс төрийн боловсрол, хүмүүжил, ухамсар соёлын төлөвшилтөд зохих нөлөөтэй төдийгүй, их дээд сургууль дахь хүмүүжлийн үйл ажиллагааны гол чиглэл байх ёстой.

Ашигласан ном зохиол

1. Н.В.Боряз."Человек и общество" .М.,1969.
2. В.Г.Лисовский, А.В.Димитров. Личность студентов. МГУ.,1974.
3. Ё.Довчин.Харьцуулсан улс төр.,УБ.,2006,
4. Л.Цэенбазар. Проблемы формирования личности в МНР. Автореф Дисс, 1991,
5. Н.Хавх. Оюутан залуучуудын нийгмийн харилцааны гүн ухааны агуулга.УБ., 2002.
6. И.С.Кон.Психология юношеского возраста.М.,1979.
7. Современное политическое сознание США.М.,1980.
8. С.Н.Иконикова. Молодежь. Изд-ва МГУ.М.,1974.
9. Социология личности М.,1967.

Краткий обзор: Формирование политического сознания граждан особенно молодёжи в такое преломное время, когда осуществляется коренные преобразования, преодолеваются застойные и кризисные процессы, в период демократизации общественной жизни. Важность задачи формирования политического сознания обусловлена тем, что она возобновляется на каждом историческом этапе развитие монгольского общества с его новыми потребностями и проблемами, с вступлением в жизнь новых поколений, которые не рождаются с готовыми политическими взглядами и ценностями. От формирования политического сознания в значительной мере зависит будущее нашего общества и молодёжь здесь должна занимать соответствующее место. В современном монгольском обществе студенческая молодёжь является не только весьма многочисленной, но и социально-активной группой. В решении задач ускоренного развития общества большие надежды возлагаются именно на молодёжь.